


Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

Ажил эхлэхээс өмнө уг журмыг уншиж танилцаад, сүүлийн хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулна үү.

АСЖ № /SWP document#	OT5955-90-SWPO-1001 R05	Урьдаар ажлаа нарийн тооц Хор хөнөөл аюул бүрийг тодорхойл Аюул дагуулсан эрсдлийг таньж мэд Аюул хөнөөлийг хяна Нэн тэргүүнд аюулгүй бай	Think through the task Recognize the hazards Assess the risk Control the hazards Keep safety first in all tasks
Хэлтэс / Department:	Ложистик Logistics		
Харъяалагдах байршил, хэсэг: Physical location and area	Ялгалтын талбай Marshalling yard		

Зорилго / ХАМРАХ ХҮРЭЭ / Үргэлжлэх хугацаа		PURPOSE / SCOPE / DURATION	
Зорилго: Purpose:	Энэхүү журмын зорилго нь ууттай баяжмалыг сэрээт ачигчаар тээврийн хэрэгсэлд ачих, буулгах ажлыг аюул осолгүйгээр гүйцэтгэхэд чиглэнэ.		
Хамрах хүрээ: Scope:	Тоног төхөөрөмжийн байршил Functional location	Тоног төхөөрөмж Functional location description	Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай хамааралтай эсэх (тийм / үгүй) Process Safety Relevant (yes / no)
Ууттай баяжмалыг ачих болон буулгах сэрээт ачигчийн операторт хамаарна.	Ялгалтын талбай Marshalling yard	Сэрээт ачигч Forklift:	☐
Нийт үргэлжлэх хугацаа: Ачих хугацаа: 1 лот - 1 сэрээт ачигчаар 4 – 4,5 цаг - 2 сэрээт ачигчаар 2,5 – 3 цаг	Буулгах хугацаа: 1 лот - 1 сэрээт ачигчаар 4,5 – 5 цаг - 2 сэрээт ачигчаар 3 – 3,5 цаг	Ажлын захиалгын цагийг дагах	

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны хүрээнд анхаарах асуудлууд HEALTH, SAFETY & ENVIRONMENTAL CONSIDERATIONS		
Аюулууд Hazards	Хор үршиг Impacts	Аюулаас сэргийлэх, өртөхгүй байх арга замууд Controls
Хүн тээврийн хэрэгсэл эсвэл сэрээт ачигчид мөргүүлэх 	Бэртэж гэмтэх, амь насаа алдах	- Ажиллах багийг томилж, Ажлын стандарт журамтай танилцана. - Ноцтой эрсдэлийн шалгах хуудсыг үнэлнэ. - Сэрээт ачигчийн оператор (цаашид “Оператор” гэх) эрх бүхий мэргэжлийн үнэмлэхтэй, дадлагажсан байна. - Ажилтан биеийн болон сэтгэл зүйн хувьд ажлаа хийх бүрэн чадвартай, алжаал ядаргаанд өртөөгүй байх шаардлагатай. - Ачилт буулгалт хийхээр тусгаарлан зассан талбай (цаашид “Ажлын талбай” гэх)-г шалгаж хүн ба тээврийн хэрэгсэл байхгүй бол хаалт хашилт болон жолооч зогсох цэгийг байрлуулна. - Ажлын талбайд зөвшөөрөлгүй хүн нэвтрэхээс сэргийлсэн тэмдэг тэмдэглэгээ ил харагдахуйц байршуулна. Жолооч болон оператор ажлын талбайд хяналт тавина. - Жолооч, операторын заавраар тээврийн хэрэгслийг ажлын талбайд оруулахдаа орчин тойрондоо ямар нэгэн саадгүй эсэхийг магадлсны дараа 1 удаа богино дуут дохиог өгч хөдөлгөөнөө эхлүүлнэ. - Найдвартай харилцаа холбоо тогтоож үйл ажиллагааг явуулна. - Жолооч тээврийн хэрэгслийн түлхүүрийг операторт өгсний дараа талбайгаас гарч зогсох цэгт очно.
Тээврийн хэрэгсэл болон сэрээт ачигч хоорондоо мөргөлдөх 	Хүнд хөнгөн бэртэл гэмтэл, эд хөрөнгийн хохирол	- Сэрээт ачигчийг ажиллуулахын өмнөх үзлэг хийнэ. - Ажлын талбайд тээврийн хэрэгсэл болон сэрээт ачигч зэрэг хөдөлгөөнд оролцохыг хориглоно. - Операторын зааварчилгаар тээврийн хэрэгсэл талбайд орж, талбайгаас гарах үйлдлийг хийнэ. - Сэрээт ачигчыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр аюулгүйн зайд зогсооно. - Оператор нь ажлын талбайг засаж дуусаагүй байхад тухайн эгнээнд тээврийн хэрэгсэл орох зөвшөөрөл өгөхийг хориглоно. - Оператор хөдөлгөөнд оролцохдоо Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм мөн ОТ сайтын С3 стандартыг дагаж мөрдөнө. - Оператор хурдны хязгаарыг чанд мөрдөнө. (10 км/ц)
Өргөгдсөн ачаа унаж цохиулах, хүн дарагдах, ууттай баяжмал хооронд хавчигдах, 	Амь нас алдах, хүнд хөнгөн бэртэл гэмтэл	- Оператор өргөлтийн ажил гүйцэтгэхдээ ОТ сайтын С6 стандартыг дагаж мөрдөнө. - Өргөлтийн ажил гүйцэтгэх үед үзэгдэх орчин хязгаарлагдсан тохиолдолд ажлаа зогсооно. 12м/с бага салхитай нөхцөлд баяжмалын сэнж сэрээт ачигчийн сэрээнд авагдах боломжгүй бол жолооч сэрээгээр өлгөж өгнө. Энэ үед сэрээт ачигч анхны байрлалд очин бүрэн зогсолт хийсэн байна. - Жолооч талбайгаас гарч аюулгүй зайд очиж дохио өгтөл сэрээт ачигч хөдөлгөөнгүй зогсоно. - Сэрээт ачигч ажиллаж байгаа тохиолдолд ажлын талбайд хүн байхыг хориглоно. Ямар ч тохиолдолд ажлын багтай найдвартай харилцаа холбоо тогтоогоогүй үед ажлын талбайд нэвтэрүүлэхийг хориглоно. - Өргөлтийн ажлыг 2 сэрээт ачигч зэрэг гүйцэтгэж байгаа үед зөвхөн “А” тал удирдан ажиллана.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

Халуун хүйтэнд гадаа ажиллах.	Нарших, ухаан алдах Арьс түлэгдэх, гэмтэх Шингэний дутагдалд орох, Гар хуруугаа хөлдөөх	- Ажил болон цаг агаарын нөхцөлд тохирсон XXX-ийг хэрэглэ. - Температураас хамаарч гадаах ажлын цагт өөрчлөлт оруулна. - Ганцааранг нь ажилд гаргахгүй. - Халуунд шингэнээ сайн нөхөх арга хэмжээ авна. - Хүйтэнд тогмтол дулаацах боломжоор хангана.
Сэрээт ачигчийн бүхээгээс бүүж, суухдаа тэнцвэр алдаж унах болон гар хуруу хаалганд хавчуулах.	Хүнд хөнгөн бэртэл гэмтэл	- Сэрээт ачигчаас бүүж суухдаа 3 цэгийн дүрмийг баримтал. - Шат, гишгүүр, бариулын бүрэн бүтэн байдлыг шалга. - Хаалганд гараа хавчуулахаас сэргийлж зориулалтын хэсгээс барьж хаалга хаана.салхитай үед хаалга савах, “тугтрах”-аас сэргийлэх арга хэмжээ авна.
Тоос, шороотой орчин, Чимээ шуугиан.	Амьсгалын замын эрхтэн болон нүдэнд тоос шороо орох, сонсох эрхтэн гэмтэх	- Цаг агаарын болон гаднын хүчин зүйлсээс шалтгаалан тоосжилт үүссэн үед амны хаалт хэрэглэнэ. - Чимээ шуугиан ихтэй үед дуу чимээнээс хамгаалж чихэвч ашиглана.
Гэрэлтүүлэг хангалтгүй орчин, Шөнийн цаг.	Хүн бэртэх гэмтэх, эд хөрөнгө хохирох	- Талбайн гэрэлтүүлэг бүрэн ажиллаж байгаа эсэх дээр хяналт тавина. - Шаардлагатай тохиолдолд зөөврийн нэмэлт гэрэлтүүлэг хэрэглэ.

Нэмж шаардагдах Хувийн Хамгаалах Хэрэгсэл | энд хатуу малгай, хамгаалалтын шил, хамгаалалтын гутал, гэрэл ойлгогчтой өмд болон урт ханцуйтай цамц зэрэг заавал хэрэглэх зүйлүүдийг тооцохгүй

Required Additional PPE | do not list standard PPE (hard hat, safety glasses, safety boots, high visibility trousers and long sleeves shirt)

Амны хаалт Dust mask Зөвхөн тоосжилт үүссэн үед		Ажлын бээлий Work gloves		Цацруулагчтай хантааз Safety vest with C/W reflective tape Зөвхөн нэг удаагийн коввол өмсөх үед	
Нэг удаагийн хувцас Disposable coverall Шаардлагатай тохиолдолд өмсөнө.		Чихний бөглөө Ear plug			

Шаардагдах зөвшөөрөл | зөвшөөрөл тус бүр дээр эрх бүхий ажилтан гарын үсэг зурж баталгаажуулна

Required Permits | all permits must be signed off by an authorized person

Ажиллах ерөнхий зөвшөөрөл General Permit to Work	☐	Хязгаарлагдмал орчинд орох Entry to a Confined Space	☐	Газар шороо ухах, малтах, нэвтрэлт Excavations and Digging	☐
Өндөр хүчдэлийн туршилт хийх High Voltage Test	☐	Цахилгаан давхар холбоос / Jumper	☐	Газар хөндөх Land Disturbance	☐
Онц аюултай ачаа өргөх бүүлгах / Performing Critical Lifts	☐	Өндөрт ажиллах / Working at Heights	☐	Өндөр хэмийн ажил гүйцэтгэх Performing Hot Work	☐
Хүчдэлтэй цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах Work on Energized Electrical equipment	☐	Цахилгаан дамжуулах шугамыг ойр ажиллах Work in Close Proximity to Overhead Lines	☐	Өндөр хүчдэлтэй харьцах High voltage access	☐
Цацраг үүсгүүрийн ойр ажил гүйцэтгэх / Working in close proximity to radiation source	☐	Төмөр торон шал, ирмэгийн хаалт хашилт буулгах / Flooring, grid mesh and handrail removal	☐	УАХЭС Нислэгийн RPAS flight	☐

Бэлтгэл ажил / TASK PREPARATION

Шаардагдах эд анги, сэлбэг болон материалын тоо хэмжээ | Required Parts or Amount of Materials

Шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл Required Equipment, Tools			
Сэрээт ачигч Forklift 		Зөөврийн гэрэл Portable light	 Дугуйн ивүүр Wheel chocks
Авто чирэгч, чиргүүл Truck, trailer	Ууттай баяжмал давхарлаж уутлах төхөөрөмж	Хаалт хашилт, Өргөлтийн ажлын анхааруулах тэмдэг	

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

		 
Сэрээ Rod 	Жолооч зогсох цэг 	
Шаардагдах лавламжууд зураг, схем, бусад АСЖ-үүд, зааварчилгаа гэх мэт Required References P&IDs, drawings, other SWPs, instructions, etc.		
Сэрээт ачигчийн ашиглалтын зааварчилгаа, гарын авлага	Сэрээт ачигчийн эрсдэлийн үнэлгээ	Цуглах цэг – 5-5 болон 5-1
Шаардагдах хүн хүч, мэргэшил / мэргэжлийн үнэмлэх Required Resources & Special Qualifications / Licenses		
Ажлыг гүйцэтгэх хүн Role	Too No	Шаардагдах мэргэжлийн зэрэг, эсвэл үр чадвар Qualification and work skill
Сэрээт ачигчийн оператор Forklift operator	1-2	Монгол улсын жолооны “В” ангилалын үнэмлэхтэй байх. Сэрээт ачигч ажиллуулах Монгол улсын эрх бүхий үнэмлэхтэй байх. Уурхайн сэрээт ачигчийн операторын сургалтанд хамрагдсан байх ба эрхийн хугацаа дуусаагүй байх.

Ажил Гүйцэтгэл | ДАРААЛАЛ / Явц

TASK EXECUTION | PROCEDURE / PROCESS

	Анхааралтай хий / Caution Required		Тухайн алхмыг бүрэн дуусах хүртэл дараагийн ажлыг бүү эхэл Do not proceed until task complete
Үе Шат Step	Хийгдэх ажлын тайлбар / Description		Ажлын онцлогоос хамааран үүсч болох аюултай нөхцлүүд, тэдгээрийг хязгаарлах боломжтой хэмжээ Specific Hazards or Acceptable Limits
1. Ажлын өмнөх бэлтгэл			
1.1 	- Ажилтан нь бүрэн амарсан бөгөөд алжаал ядаргаанд өртөөгүй байх шаардлагатай. - Ажлын Стандарт Журал (АСЖ)-тай танилцан гарын үсэг зурж баталгаажуулна. - Сэрээт ачигчийн оператор (цаашид “Оператор” гэх) ээлжийн ажлын төлөвлөгөөг ахлах ажилтнаас авна. - Радио станц бүрэн ажиллаж байгаа эсэх, батерейн цэнэг дүүрэн эсэхийг шалгана. - Ноцтой эрсдэлийн шалгах хуудсыг ажлын талбар дээр очиж үнэлнэ.		✓ Ажилтан өөрөө УХААН үнэлгээг хийж болно. ✓ Станцгүй ажилд гарахыг хориглоно.
1.2 	- “Сэрээт ачигч ажиллуулахын өмнөх үзлэг”-ээ хийнэ. - Ачилт хийхийн өмнө лотны сэнж босгосон эсэхийг оператор өөрөө шалгана. - Сэрээт ачигч Маршал яард (МЯ)-ын 1-р талбайд нэвтрэхдээ заавал гарах хаалгаар орно.		✓ Сэрээт ачигчийн бүхээгээс бууж, суухдаа 3 цэгийн тулгуурын дүрэм баримтлана. ✓ Ачих болон буулгах талбай бүрэн чөлөөлөгдөөгүй, хүн байгаа тохиолдолд талбай засаж эхлэхийг хориглоно. ✓ Сэрээт ачигчаар RFID хаалган доогуур нэвтрэхийг хориглоно.
1.3 	- Ажил эхлэхийн өмнө ямар нэгэн аюул, эрсдэлтэй зүйл ажиглагдсан тохиолдолд бэлтгэл ажлыг зогсоож ахлах ажилтанд мэдэгдэнэ.		
2. Ажлын талбай бэлтгэх			
2.1 	- Оператор аливаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зөөвөрлөхөөс өмнө нүдэн үзлэг хийнэ. - Ачилт буулгалт хийхээр тусгаарлан зассан талбай (цаашид “Ажлын талбай” гэх)-г өөрийн биеээр засна. Шаардлагатай тохиолдолд бусдаас түслалцаа авч болно.		✓ Ажлын талбайд сэрээт ачигч маягаа байнга ажиллуулна.
2.2 	- Оператор хаалт хашилт болон “Жолооч зогсох цэг(ЗЦ)-ийг С6 стандартын дагуу сэрээт ачигчийг ажиллуулах ерөнхий шаардлагыг мөрдөн аюулгүй зөөвөрлөнө.		✓ Хаалт хашилт болон жолооч зогсох цэгийг хамтад нь зөөвөрлөхийг хориглоно. ✓ Хаалт хашилтын конус хоорондын зай сууриараа 1.5м -ээс ихгүй байна.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах




- ✓ Жолооч зогсох цэгийг ухарч зөөвөрлөнө.
- ✓ Оператор “Жолооч зогсох цэг”-ийг конусаас 7м-ээс багагүй зайд талбайн нөхцөл байдал болон ачилт буулгалтын тээврийн хэрэгсэл талбайгаас гарахад аюулгүй байхаар тооцон орчноо бүрэн хянах боломжтой А тал эсвэл Б талын аль нэг цэгт байрлуулна.
- ✓ Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед оператор ямар нэгэн хөдөлгөөн хийхийг хориглоно.
- ✓ Оюу Толгойн хаалт хашилт, тэмдэг, тэмдэглэгээний журмыг мөрдөнө. (Баримт бичгийн дугаар: ОТ-10-PRC-0006-М 4.2. Байрлуулах болон зохицуулалт)

2.3



- Сэрээт ачигчийн оператор аюулгүй байдлыг ханган ачилт буулгалтын талбайн хаалт хашилтыг 360° тэгш хэмтэй засах Т/Х-с 4-5м зайд байрлуулна. засаж дуусаад ахлах ажилтанд мэдэгдэж зөвшөөрөл авна.
- Зөвшөөрөл авсаны дараа тээврийн хэрэгсэл (ТХ)-ийг ажлын талбайд оруулна.



- ✓ Талбай бүрэн бэлдэж дуусаагүй үед тээврийн хэрэгсэл оруулахыг хориглоно.

3. Тээврийн хэрэгслийг ажлын талбайд оруулах

3.1

- Жолооч ТХ-ийг ажлын талбайд ойртуулж зогсооно.
- ТХ-ийг ямар чиглэлээр оруулах, хаана зогсоохыг оператор зааварлана.

- ✓ ТХ-ийн жолоочийн талыг “А” тал гэнэ. Жолоочийн эсрэг талыг “Б” тал гэнэ.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

 	- ТХ-ийг ажлын талбайд оруулах болон зогсоох дохиог зөвхөн жолоочийн зүүн гар талын сэрээт ачигчийн оператор гараар болон станцаар, шөнө бол гэрэл ашиглан өгнө. - Жолооч тусгаарласан талбайд орохдоо 1 удаа “богино” дуут дохио өгч анхааруулна. 	✓ Ачилтын талбайд операторын зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно. ✓ Ажлын талбайд 2 оператор ажиллах бол ажил эхлэхийн өмнө хэн нь аль талдаа ажиллахаа тохирсон байна. ✓ Жолоочийг гялбуулахаас сэргийлж сэрээт ачигчийг ТХ-ийн чиглэлтэй, 45° налуу байрлалтай байрлуулна. ✓ ТХ-ийг хураалттай баяжмалаас 8м-ээс багагүй зайд байхаар тооцон зогсооно. ✓ Ажлын талбайн гадна хүлээж байгаа ТХ их гэрлээ унтрааж оврын гэрэлтэй хүлээнэ. ✓ “Б” талын оператор ТХ-ийг оруулах, зогсоох дохио өгөхийг хориглоно. ✓ “Б” талын оператор ачигчаас бүүж талбайгаас гарах бол “А” талын ногоон конусаар гарна. ТХ-ийг конуснаас 4-5м метр зайтай зогсооно.
3.2  	- Жолооч ажлын талбайд зогсохдоо: 1. Хөдөлгүүрээ унтрааж гар тоормос татна. 2. Кабинаас буусан даруй дугуйн ивүүрээ чирэгчийн зөв талын дунд тэнхлэгийн гадна дугуй (3-р)-ны хоёр талд байруулна. - Аваарын гэрлийг асаалттай үлдээнэ.   - Жолооч ТХ-ийн түлхүүрийг сэрээт ачигчийн гадна байрлах “түлхүүрийн хайрцаг”-т хийнэ.   - Жолооч ажлын талбайгаас гарч ЗЦ-т очиж операторт гараа өргөн “талбайгаас бүрэн гарсан”-аа мэдэгдэнэ. 	✓ Жолооч, ТХ-ийг операторын заасан цэгт зогсооно. ✓ Жолоочийг ЗЦ-т очиж дохио өгөх хүртэл оператор хөдөлгөөн хийлгүй хүлээнэ. ✓ Ачилт, буулгалт хийх явцад жолооч ЗЦ-т хүлээнэ. ✓ ЗЦ дээр гар утас ашиглахыг хориглоно. ✓ ТХ ухрах тохиолдол гарвал заавал дохиочин ашиглана. Дохиочингүй ухрах үйлдэл хийхийг хориглоно.


3.3




Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.





- ✓ 1 ажлын талбайд 2 сэрээт ачигч зэрэг ажиллах үед "А" талын оператор удирдан ажиллана.
- ✓ Нэг талаас ачих эсвэл буулгахдаа:
 - Зураг.02 Дан чиргүүлтэй ТХ бол чиргүүлийг лотны голоос урагш зогсооно.
 - Зураг.03 Давхар чиргүүлтэй ТХ бол 2-р чиргүүлийг лотны голоос урагш зогсооно.
- ✓ Арын ТХ зассан талбайн гадна конуснаас 4-5 метр зайд зогсож хүлээнэ.
- ✓ ТХ ажлын талбай руу орж байх үед оператор нэмэлт гэрлээ унтраасан байна.

4. СЭРЭЭТ АЧИГЧААР АЧИЛТ ХИЙХ

4.1

Сэрээт ачигчаар нэг талаас ачилт хийх болон буулгалт хийх:


- Ачилтыг ямагт "А" талаас эхлэнэ.
- Хураалттай баяжмалын эсрэг талд байрласан оператор чиргүүлийн хойгуур тойрч өөрийн талаа хөөж ачна.
- Хоёр сэрээт ачигч нэг дор давхцахгүй байхаар ачилт хийнэ.
- [Зураг.02](#) , [Зураг.03](#)




- ✓ Сэрээт ачигчууд огтлолцох, давхцах хөдөлгөөн хийхийг хориглоно.
- ✓ "А" болон "Б" талын сэрээт ачигч нэгэн зэрэг тэвшинд ойртон ирсэн тохиолдолд "А" тал эхэлж тэвшинд ачна. Бусад тохиолдолд түрүүлж чиргүүлд ойртсон нь ачна. Буулгалт мөн адил.
- ✓ Сэрээнд сэнж бүрэн өлгөгдөхгүй бол 2 талын оператор сэрээт ачигчийг ачилт эхэлсэн анхны байрлалд аваачин парклаад (хөдөлгүүрээ унтрааж сэрээг газарт буулган зогсоолын тормоз идэвхжүүлэх) станцаар харилцан сэнжийг босгуулах ажлыг эхлүүлнэ.
- ✓ Сэнж босгосон жолооч талбайгаас гарч аюулгүй зайд очоогүй байхад сэрээт ачигч хөдөлгөөн хийхийг хориглоно.
- ✓ Сэнж босгосон жолооч талбайг бүрэн чөлөөлж дохио өгсний дараа оператор ажлаа үргэлжүүлнэ.

Сэрээт ачигчаар хоёр талаас ачилт хийх:


- Ачилтыг ямагт "А" талаас эхлэнэ.
- Зураг.04



Зураг.05 үзүүлснээр 2 сэрээт ачигч нэг хоёр талд буулгасан лот ачихад зэрэгцэж ачилт хийхийг хатуу хориглоно.



Нэг сэрээт ачигчаар чиргүүлд ууттай баяжмал ачих ажлын дарааллыг Зураг.06 -д харуулснаар 1-р чиргүүлээс эхлэн 6-10-4 гэсэн дарааллаар ачна.




5. УУТТАЙ БАЯЖМАЛЫГ СЭРЭЭТ АЧИГЧААР БУУЛГАХ

Ууттай баяжмалыг сэрээт ачигчаар нэг талруу буулгах

5.1

Ууттай баяжмалыг энэхүү зургийн дагуу хоорондын зайг баримталж талбайд буулгана.

- 20ш баяжмалыг 1 эгнээнд жагсаан байрлуулна.
- 2 дахь эгнээг буулгаж дуусаад 3 дахь эгнээг эхлэхдээ 0.5 - 1м зай авна.




- ✓ Ажлын талбайд зөвхөн 1 ТХ байрлуулна.
- ✓ Баяжмалыг тэмдэглэгдсэн байршил дээр тэгш байрлалд, хэт шахахгүй буулгаж өрнө.
- ✓ Хазгай суурьтай баяжмалыг тэгшилж хураана.
- ✓ Хооронд нь хэт шахаж эсвэл хазгай, муруй буулгахыг хориглоно.
- ✓ Ажлын талбайд буулгасан баяжмалыг тэгшлэх шаардлага гарвал жолоочид түлхүүр өгөхөөс өмнө, эсвэл ТХ-ийг талбайгаас бүрэн гарсаны дараа тэгшлэнэ.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

5.2

Нэг багц (LOT) ууттай баяжмалыг талбайд байрлуулахдаа доорх зурагт заасан хэмжээг мөрдөж хоёр тэнцүү хэсэгт хувааж буулгана.



✓ Эгнээ байрны дараалал алдагдуулах, мөн хольж буулгахыг хориглоно.

5.3




- Баяжмалыг чиргүүлийн урд талаас эхлэн буулгана.
- Оператор эхлээд ачааг тэвшнээс дээш өргөн 0,2-0,3 метр хөндийрүүлж ачааны тэнцвэр, сэнжний бүрэн бүтэн байдлыг шалгана (Шилжих хөдөлгөөн хийхгүй).
- Дараа нь ачааг жигд хөдөлгөөнөөр шилжүүлэх үйлдлийг хийнэ.



- Дээрх алхмыг давтан гүйцэтгэж дараагийн ууттай баяжмалуудыг буулгана.

Оператор доорх эрсдэлүүдийг тооцож ажиллана.

- ✓ Оператор давхар үйлдэл хийхийг хориглоно.
- ✓ Сэрээт ачигчийн нэг сэрээгээр өргөх үйлдэл хийхийг хориглоно.



5.4



- Оператор ууттай баяжмалыг газраас сэрээт ачигчийн урд дугуйны радиусын хэмжээ хүртэл буулгана.



- ✓ Ухрах үйлдэл хийхдээ операторууд анхаарал болгоомжтой хийнэ.

5.5



- Ууттай баяжмалыг сэрээт ачигчаар нэг талруу буулгах
- Буулгалтыг ямагт "А" талаас эхлэнэ.


- ✓ Буулгалтын талбайд зөвшөөрөлгүй хүн нэвтрэхийг хатуу хориглоно.
- ✓ Сэрээт ачигчууд огтлолцох, давхцах хөдөлгөөн хийхийг хориглоно.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах




- Б талын сэрээт ачигчийн оператор тээврийн хэрэгслийн чиргүүлийн хойд хэсгээр тойрч Б талаа хөөж буулгана. Хоёр сэрээт ачигч нэг дор давхцахгүй байхаар **Зураг.07 & Зураг.08** дагуу буулгалт хийнэ.

Зураг.7



Зураг.08




- ✓ “А” болон “Б” талын сэрээт ачигч нэгэн зэрэг тэвшинд ойртон ирсэн тохиолдолд “А” тал эхэлж тэвшнээс өргөж авна. Бусад тохиолдолд түрүүлж чиргүүлд ойртсон нь буулгана.
- ✓ Буулгалтын сэнж бэлдэж өгөх жолооч болон ажилтан - “Сэрээ төмөр ашиглан баяжмалын сэнж босгох, газраас ачигдах баяжмалын сэнжийг бэлтгэх” АСЖ-тай танилцсан байна.
- ✓ Хугарсан, гэмтэлтэй эсвэл хэт богино сэрээ ашиглахыг хориглоно.
- ✓ Баяжмалын сэнжийг операторын харах өнцөгт тааруулж бэлдэнэ.
- ✓ Оператор ажлын талбайд огцом хөдөлгөөн эргэлт хийхгүй байх, хурдаа хянаж байх шаардлагатай.
- ✓ Ажлын талбайд эргэлтийн радиус, зайгаа сайн тооцож засна.
- ✓ Сэрээнд сэнж бүрэн өлгөгдөхгүй бол 2 талын оператор сэрээт ачигчийг ачилт эхэлсэн анхны байрлалд аваачин парклаад (хөдөлгүүрээ унтрааж сэрээг газарт буулган зогсоолын тормоз идэвхжүүлэх) станцаар харилцан сэнжийг босгуулах ажлыг эхлүүлнэ.
- ✓ Сэнж босгосон жолооч талбайгаас гарч аюулгүй зайд очоогүй байхад сэрээт ачигч хөдөлгөөн хийхийг хориглоно.
- ✓ Сэнж босгосон жолооч талбайг бүрэн чөлөөлж дохио өгсний дараа оператор ажлаа үргэлжүүлнэ.


5.6

Ууттай баяжмалыг сэрээт ачигчаар хоёр талруу буулгалт хийх:

- Буулгалтыг ямагт "А" талын 1-р чиргүүлээс эхлүүлнэ. "А" сэрээт ачигч нь чиргүүлийн А талд, "В" сэрээт ачигч нь чиргүүлийн В талд байрлаж буулгалтыг хийнэ. **Зураг.09**




- Зураг.10 үзүүлснээр 2 сэрээт ачигч нэг талд зэрэгцэж буулгалт хийхийг хатуу хориглоно.



5.7




- Зураг.11 Нэг сэрээт ачигчаар буулгах тохиолдолд ууттай баяжмалыг чиргүүл дээрээс 6/10/4 гэсэн харьцаагаар "А" талаас эхлэн талбайд буулгана.



Нам тавцант чиргүүлээс сэрээт ачигчаар буулгах.

- Сэрээт ачигчийн самбараар чиргүүлийг мөргөхөөс сэргийлж хоорондын зайг хянаж ажиллана.
- Ууттай баяжмалыг нам тавцант чиргүүлийн порчикноос 20см өндөр өргөж буулгана.
- **Зураг.12** 2 сэрээт ачигч тавцанд зэрэг ойртохгүй. Нэг нь чиргүүлээс авч байхад нөгөө нь газарт буулгаж байхаар тооцож ээлжлэн ажиллана.



Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

5.8	- Үзэгдэх орчин хязгаарлагдсан (салхи шуурга, манан, тоосжилт ихтэй) нөхцөлд ахлах ажилтны шийдвэрээр ажлыг зогсооно. Салхины хурд 12 м/с-ээс дээш үед ажлыг бүрэн зогсооно. - - Шаардлагатай тохиолдолд (салхитай, сэнж сэрээнд өлгөгдөхгүй байх г.м) жолоочоос тусламж авч болно. - Жолооч сэнж өлгөж өгөх тохиолдолд - “Сэрээ төмөр ашиглан баяжмалын сэнж босгох,газраас ачигдах баяжмалын сэнж бүрийг урьдчилан бэлтгэх” АСЖ-тай танилцсан байна.	✓ Сэрээт ачигчийг унтрааж сэрээг газарт буулган зогсоолын тормоз идэвхжүүлэхийг “бүрэн зогсолт” гэж ойлгоно. ✓ Оператор кабинаас бүүх тохиолдолд дугуйн ивүүр заавал хийнэ.
5.9	Тээврийн хэрэгсэлийг буулгалтын талбайгаас гаргахдаа энэхүү АСЖ-ын 6-р заалтийн дагуу хийж гүйцэтгэнэ.	
5.10	Ууттай баяжмал цоорсон, зүсэгдсэн мөн сэнж тасарсан байвал давхарлаж уутлана. Энэхүү АСЖ-ын 8-р алхмаас харна уу	
5.11	- Сэрээт ачигчийн оператор бэлтгэсэн сэнжийг ачигчийн сэрээнд мултрахааргүй өлгөж ачааг газраас дээш өргөж 0,2-0,3 метр хөндийрүүлж ачааны тэнцвэр болон оосрын бүрэн бүтэн байдлыг шалгана. (Шилжилт хөдөлгөөн хийхгүй). - - Хяналтын өргөлт хийсний дараа ууттай баяжмалыг газраас урд дугуйны радиусын хэмжээнд хүртэл өргөж зөөвөрлөнө. - Хэрэв өргөлтийг цааш үргэлжлүүлэхэд сэнж мултрах, ачаа унах эрсдэлтэй бол газар буулгаж дахин өргөлт хийнэ.	
5.12	- Сэрээт ачигч баяжмалыг савлуулахгүй бага хурдаар (удаан) хөдөлж явна. - Чиргүүлээс 1-2 метрийн зайд очин ууттай баяжмалын суурийг чиргүүлийн тавцангаас дээш 0,2 - 0,3 метрийн хэмжээнд хүртэл өргөж ачилт хийнэ.	✓ Сэрээт ачигчийн цамхгаар чиргүүл мөргөх, баяжмалыг тавцан дээр хүчтэй буулгаж ачиж болохгүй.
5.13	- Хэрэв баяжмал хазгай буюу унах эрсдэлтэй ачигдсан бол тэгшилж ачна.	✓ Оператор ууттай баяжмалыг тэвшин дээр тэгш ачна.
5.14	- ТХ-ийг ачилтын талбайгаас гаргахдаа энэхүү АСЖ-ын 6-р заалтийг мөрдөнө.	
5.15	- Ууттай баяжмал цоорсон, зүсэгдсэн мөн сэнж тасарсан байвал давхарлаж уутлана. Энэ АСЖ-ын 8-р алхамыг харна уу.	
6. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ АЖЛЫН ТАЛБАЙГААС ГАРГАХ		
6.1	- Ачилт болон буулгалт дууссаны дараа оператор, сэрээт ачигчийг анхны байрлалд зогсоож сэрээг газарт буулган хөдөлгөөнгүй байрлуулна. - Оператор жолоочид өдрийн ээлжинд гараараа дохиж, шөнийн ээлжинд нэмэлт гэрлээ унтрааж ажлын талбайд орох зөвшөөрөл өгнө.	✓ Оператор орох зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд жолооч талбайд орохыг хориглоно.
6.2	- Жолооч ТХ-ийн түлхүүрийг сэрээт ачигчийн гадна байрлах түлхүүрийн хайрцагнаас авна. - Дугуйн ивүүрээ авч тээврийн хэрэгслийг асаан хийгээ шалгаад, богино дуут дохио өгч талбайгаас гарч явна.	✓ Сэрээт ачигч парклаагүй үед жолоочид түлхүүр өгөх буюу жолоочыг талбай руу оруулахыг хориглоно. ✓ Жолооч ТХ-ийг талбайгаас бүрэн гаргах хүртэл сэрээт ачигч хөдөлгөөн хийхийг хориглоно.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

		
6.3 	- ТХ-ийг талбайгаас бүрэн гараагүй тохиолдолд сэрээт ачигч буюу оператор ямар нэгэн хөдөлгөөн хийхийг хориглоно.	✓ Ажлын талбайд сэрээт ачигч, тээврийн хэрэгсэл зэрэг хөдөлгөөн хийхийг хориглоно.
7. Сэрээт ачигч талбайд орох болон гарах		
7.1 	- “А” талын сэрээт өргөгч талбайгаас гарах болон орохдоо “Б” талын сэрээт өргөгчтэй НХХ тогтоон хийж буй үйлдлээ дуусган анхны байрлалд очиж хөдөлгөөнөө зогсоож гарах болон орох зөвшөөрөл өгсний дараа “А” талын сэрээт өргөгч талбайгаас гарах болон орно.	✓ Найдвартай харилцаа холбоог тогоож ажиллах ✓ Ажлын талбайд сэрээт ачигч хөдөлгөөн хийхийг хориглоно.
7.2 	- “Б” талын сэрээт өргөгч талбайгаас гарах болон орохдоо “А” талын сэрээт өргөгчтэй НХХ тогтоон хийж буй үйлдлээ дуусган анхны байрлалд очиж хөдөлгөөнөө зогсоож гарах болон орох зөвшөөрөл өгсний дараа “Б” талын сэрээт өргөгч талбайгаас гарах болон орно.	✓ Найдвартай харилцаа холбоог тогоож ажиллах ✓ Ажлын талбайд сэрээт ачигч хөдөлгөөн хийхийг хориглоно.
7.3 	- “А”, “Б” сэрээт өргөгч анхны байрлалд очоод “А” талын сэрээт өргөгчийн оператор Т/Х-н жолоочийг дуудан түлхүүрийг “Б” талын операторт шилжүүлэн өгүүлэнэ. Жолооч буцан жолооч зогсох цэгт очин дохио өгсөн дараа “А” талын сэрээт өргөгч талбайгаас гарна. “Б” талын сэрээт өргөгч ажлыг үргэлжлүүлэн дуусгаад “А” талд гарна.	✓ “А” талын сэрээт өргөгч талбайгаас гартал “Б” талын сэрээт ачигч хөдөлгөөн хийхийг хориглоно.
7.4 	- 2 сэрээт өргөгч талбайгаас зэрэг гарах болон орохдоо. Анхны байрлалд 2 сэрээт өргөгч очиж зогссоны дараа “Б” талын сэрээт өргөгч талбайгаас НХХ тогтоон түрүүлж талбайгаас гарна. - Түрүүлж ирсэн сэрээт өргөгч талбайд орж байрлана. Сүүлд ирсэн сэрээт өргөгч орох зөвшөөрлөө талбайд багаа сэрээт өргөгчөөс авч НХХ тогтоосны дараа орно энэ үед эхлээд орсон СӨ анхны байрлалд зогссон байна	✓ Түрүүлж ирсэн сэрээт өргөгч сүүлд ирсэн сэрээт ачигч НХХ тогтоон талбайд орж анхны байрлалд зогох хүртэл хөдөлгөөн хийхийг хориглоно. ✓ Найдвартай харилцаа холбоог тогоож ажиллах
8. Ууттай баяжмал давхарлаж уутлах		
8.1 	- Ахлах ажилтанд мэдэгдэж уут давхарлах ажил гүйцэтгэнэ. - “Уут давхарлах төхөөрөмж” зөөвөрлөхөөс өмнө уг төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг үзэж шалгана. - Бичлэг хэлбэрээр үзэж болно	✓ Уут давхарлах үйл ажиллагаанд жолоочыг оролцуулах бол уг жолоочид энэхүү АСЖ-ыг танилцуулсан байна. ✓ Төхөөрөмжийн голоор татсан гинжийг бүрэн бэхлэгдсэн эсэхийг сайтар үзэж шалгана.
8.2    	- Төхөөрөмж зөөвөрлөхдөө төхөөрөмжийн голоор татсан гинжийг угсрагдсан эсэхийг шалган онгойх хаалганы эсрэг талаас сэрээт ачигчаар өргөсний дараа цамхагийг гэдийлгэн хурдны хязгаарыг баримтлан удаан явна.	✓ Зөвшөөрснөөс бусад талаас сэрээг оруулан өргөхийг хатуу хориглоно. ✓ Уут давхарлах төхөөрөмжийг буулгалт болон ачилтын талбайд байрлуулахдаа дараагын үйлдэл хийхэд саад болохооргүйгээр байрлуулна.

		
8.3 ⚠ 🚫	- Баяжмал давхарлах уут бэлтгэж дэлгэсэн байна. - Сэрээт ачигч холдсоны дараа жолооч, оператор төхөөрөмжийн голоор гүйлгэсэн гинжийг мултлан давхарлах уутаа дээрээс нь углан хийж богино сэнжнүүдийг гадна байрлах түгжээнд тогтооно. - Санамж: Урт оосрыг төхөөрөмжийн гадуур цэнхэр будагтай талд байрлуулна.  	✓ Гар болон бусад зүйлсээ төхөөрөмжид хавчуулахаас сэргийлэх хэрэгтэй. ✓ Уутыг төхөөрөмжинд углаж дуусаад ажилчид хаалт хашилттай талбайгаас гарч зогсоно.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

		
8.4   	- Оператор ууттай баяжмалыг өргөж зөөхдөө 5, 6-р алхамыг мөрдөнө. - Төхөөрөмжөөс дээш 15-20см өндөр өргөн баяжмалаа бэлтгэсэн уутанд голлуулан удаанаар доош буулгасны дараа сэрээг сэнжнээс гаргана. 	✓ Баяжмал давхарлах явцад ойр байгаа хүмүүс хаалт хашилтын гадна аюулгүй зайд гарч байрлана. ✓ Төхөөрөмжийн хаалгатай талаас ууттай баяжмалыг өргөж давхарлана.
8.5  	- Сэрээт ачигч давхарлах төхөөрөмжөөс холдож 5-н метрын зайнд очин паркалсаны дараа туслах ажилтанд талбайд орох зөвшөөрөл өгнө. 	✓ Оператор зөвшөөрөл өгөөгүй байхад туслах ажилтан давхарлах төхөөрөмжинд ойртохийг хориглоно.

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

8.6  	- Операторын зөвшөөрлөөр туслах ажилтан төхөөрөмжид бэхэлсэн уутны богино сэнжийг түгжээнээс гаргаж хаалгыг онгойлгон давхарласан ууттай баяжмалын сэнжийг босгосны дараа талбайгаас гарч операторт дохио өгнө.  ТӨХӨӨРӨМЖИЙН ДООД ТАЛЫН ТҮГЖЭЭГ ЭХЭЛЖ ГАРГАНА ДАРАА НЬ ДЭЭД ТАЛЫН ТҮГЖЭЭГ ГАРГАНА	✓ Туслах ажилтан төхөөрөмжөөс холдоогүй үед сэрээт ачигч төхөөрөмжинд ойртож болохгүй. ✓ Төхөөрөмжийн доод талын түгжээг эхэлж гаргана. Дараа нь дээд талын түгжээг гаргана.
талбайн 8.7  	- Сэрээт ачигч төхөөрөмжийн хаалгатай талаас очиж ууттай баяжмалыг төхөөрөмжөөс удаанаар болгоомжтой дээш өргөн гаргаж авна. 	✓
8.8    	- Төхөөрөмжийг зөөвөрлөхдөө голоор гүйлгэсэн гинжийг бүрэн угсарч хаалганы эсрэг талаас өргөн цамхагийг гэдийлгэж талбайн хурдны хязгаарыг мөрдөж явна. - Төхөөрөмжийг 90-р постын баруун хэсэгт байрлуулна. 	✓ ТХ талбайгаас гарсны дараа оператор төхөөрөмжийг зөөвөрлөнө.
9. Ажлаа дуусгах		
9.1	Ажлын талбайгаас хэрэглэсэн эд ангиудыг цэвэрлэж авна.	
9.2	Тоног төхөөрөмж, бусад хэрэгслүүдийг цэвэрлэн, зориулалтын байранд нь буцаана.	
9.3	Ажил бүрэн гүйцэтгэж дууссан уу?	
НЭМЭЛТ ТЭМДЭГЛЭЛ / ADDITIONAL COMMENTS:		

Сэрээт ачигчаар баяжмал ачих болон буулгах

Бичиг баримтын мэдээлэл / DOCUMENT INFORMATION

Мөрдөж эхлэх огноо Effective:	2025/02/18	Хянах огноо: Review due:	2027/02/18
Хянан өөрчилсөн дугаар: Revision:	R05	Ажлын зэрэг (4-Дээд - 1-Бага): Priority rating (4-High to 1-Low):	2-Дунд

ХЯНАН ЗАСВАРЛАСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ / REVISION HISTORY

ӨМ дугаар MOC #	Хийгдсэн өөрчлөлт Description of Change	АСЖ-ыг боловсруулсан SWP Developer	АСЖ-ыг хариуцах ажилтан SWP Custodian	АСЖ-ыг батласан SWP Approver	Боловсруулсан огноо (О/С/Ө): Created M/D/Y:
	Эх хувь Initial Release	Ганчулуун Шинэсүх	Ганчулуун Шинэсүх	Ганбат Баттулга	2020/06/15
R02	Сэрээт ачигчийн ажиллах цагийг өөрчилж дахин хянав.	Будсүрэн Баяраа	Будсүрэн Баяраа	Ганчулуун Шинэсүх	2021/03/10
R03	Угсраа чиргүүлтэй болон нам тавцант тээврийн хэрэгслийн хяналтын арга хэмжээ, Алхам бүр дээр дэвхардсан хяналтыг хассан. Зураг шинэчилсэн	ОТ Үйл ажиллагаа Экспорт баг	Будсүрэн Баяраа	Ганчулуун Шинэсүх	2023/04/01
R04	6.1 Оператор жолоочид өдрийн ээлжинд гараараа дохиж, шөнийн ээлжинд нэмэлт гэрлээ унтрааж ажлын талбайд орох зөвшөөрөл өгнө.	ОТ Үйл ажиллагаа Экспорт баг	Будсүрэн Баяраа	Ганчулуун Шинэсүх	2024/12/20
R05	2.3-р алхамд найруулга хийсэн, талбайн зургуудад өөрчлөлт оруулсан, 7-р алхам дээр сэрээт өргөгч талбайгаас орох болон гарах хэсгийг шинээр нэмсэн.	ОТ Үйл ажиллагаа Экспорт баг	Баатар Батбаяр	Ганчулуун Шинэсүх	2025/02/18

Ажилтны мэдээлэл / WORKER INFORMATION				АСЖ-тай ТАНИЛЦСАН READ SWP
№	Албан тушаал / role	Ажилтны нэр / Worker name	Хувийн дугаар SAP number	Гарын үсэг / Sign
1.				
2.				
3.				
4.				
5.				
6.				
7.				